



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2021 ОНЫ 3, 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль”, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно. Тайлант хугацаанд дараах ажил үүргийг гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус нийт 12 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100%-ийн ирцтэйгээр дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудлыг 2 удаа,
- Зээл олгох, зээлийн шугам нээх, баталгаа, батлан даалт, аккредитив нээхтэй холбоотой асуудлыг хэлэлцэж 12 зээлдэгчид зээл олгохоор шийдвэрлэсэн,
- Банкны эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээдэд зээл олгох асуудлыг хэлэлцэж 4 зээлдэгчид зээл олгохоор шийдвэрлэсэн,
- Дотоод аудитийн газрын үйл ажиллагаатай холбоотой 8 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн /Дотоод аудитын газрын төлөвлөгөө, бүтэц, зохион байгуулалт, орон тоо шинэчлэх, аудитор томилох, чөлөөлөх тухай зэрэг асуудлууд/,
- Банкны салбар нэгж байгуулах, татан буулгах тухай 8 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн,
- Банкны 2021 оны төсвийн тодотгол хийх, 2022 оны Бизнес төлөвлөгөөг батлах тухай болон банкны орон тоо, бүтэц зохион байгуулалтын тухай асуудлыг 3 удаа хэлэлцэж шийдвэрлэсэн,
- Гүйцэтгэх удирдлагын ажлын тайлантай танилцаж, дүгнэх тухай асуудлыг 2 удаа хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасан,
- Эрсдэлийн сангаас авлага хаах, хөрөнгө банкны бүртгэлээс хасах, актлах тухай 3 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн,
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн шинэчлэх, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, шинээр томилох тухай, Гүйцэтгэх захирлын дэргэдэх зээлийн

хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлахыг зөвшөөрөх тухай 3 асуудлыг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасан,

- Банкныг ХК болгох төлөвлөгөөний хүрээнд шийдвэрлүүлэх асуудалтай танилцах, Кредит банктай нэгтгэхтэй хобоотойгоор хөрөнгө гаргах тухай 2 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн,
- Гүйцэтгэх захиралд хэлцэлд оролцох эрх олгох тухай асуудлыг 2 удаа хэлэлцэж шийдвэр гаргасан,
- Бусад асуудлууд /Кредит банкны тооцооны төвд байршиж байсан харилцах дансны тухай, Хүүгийн эрсдэлийг удирдах журамд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах, банкны ажилчдын 2021 оны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан урамшуулалт цалинг олгох, нэр бүхий компанитай худалдах, худалдан авах гэрээ хийх эрхийг Гүйцэтгэх захиралд олгох/.

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитийн хороо нь тайлант хугацаанд Дотоод аудитийн газраас хувийн банкны газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан, байгууллагын харилцааны газрын ажилтнуудын дебит картын ашиглалтад хийсэн шалгалтын тайлан, хадгаламжийн гэрээг түүвэрчлэн шалгасан тухай тайланг авч хэлэлцсэн болно. Хурлаар харилцах, хадгаламжтай холбоотой программ хангамжийн асуудлуудыг шийдэх, харилцах, хадгаламжийн гэрээ болон хувийн хэргийн бүрдлийг хангаж ажиллах, ажилтнуудын дебит картын ашиглалтад хяналт тавьж ажиллах, үүссэн өр төлбөрийг барагдуулж ажиллах үүрэг даалгавар өгсөн болно.

3. Эрсдэлийн хороонд ажилласан тухай:

Банкны Эрсдэлийн хороо нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт болон эрсдэлийн ерөнхий түвшинтэй танилцаж, “Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, эрсдэлийн хязгаар, түүнийг дагаж мөрдөх журам”-ын хавсралтыг шинэчлэн батлах асуудлуудыг хэлэлцсэн болно. Хурлаар Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын газарт Ковидын хуулийн дагуу зээлийн сунгалт хийгдэж байгаатай холбоотой зээлийн ангилал, түүнээс үүсэх эрсдэлийн талаар судалж, танилцуулах, “Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, эрсдэлийн хязгаар, түүнийг дагаж мөрдөх журам”-ын хавсралтыг шинэчлэн баталж, журмын хэрэгжилтийн хяналтын тогтолцоог сайжруулах, шат дараатай хяналтыг бий болгох тал дээр анхааран ажиллах үүрэг даалгавар өгсөн болно.

Тайлан гаргасан:

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Оюунцацрал